



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар A/106

Улаанбаатар хот

Г Нийтлэг шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хавсралтаар баталсан нийтлэг шаардлагад нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж хэрэгжүүлэхийг төрийн болон орон нутгийн ёмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

3.Нийтлэг шаардлагад нийцүүлэн дотуур байрны багшийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ үр дүнтэй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт даалгасугай.

САЙД



14251 0326

Боловсролын сайдын 2025 оны  
03 дугаар сарын 18 нийтлэгийн  
106 дугаар тушаалын хавсралт

ATA12937-011647-19024070582

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ БАГШИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Нэг. Дотуур байрны багшийн боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Багш, бага боловсрол /0113/, Багш, мэргэжлийн /0114/, нийгмийн ажил /0923/, сэтгэл судлал /0313/. Багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдаж төгссөн (багшлах эрхийн гэрчилгээ) байх
Мэргэшил	Дотуур байрны багшаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно.
Туршлага	Мэргэжлээрээ боловсролын байгууллага, эсхүл хүүхдийн байгууллагад ажилласан байх

Дээд боловсролын сургалтын байгууллагыг багш, нийгмийн ажил, сэтгэл судлал мэргэжлээр төгссөн, боловсролын сургалтын байгууллагад анхны жилдээ ажиллах багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон Боловсролын ерөнхий хуулийн 12.16-д заасан дагалдан багшид туршлагын шаардлага хамаарахгүй.

Хоёр. Дотуур байрны багшийн мэдлэг,  
ур чадварт тавих шаардлага

2.1. Дотуур байрны багш нь энэхүү шаардлагын гуравт заасан ажил үүргийг гүйцэтгэхэд дараах мэдлэг, ур чадвар эзэмшсэн байна.

### 2.1.1. Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг:

- хүүхдийн сэтгэл судлал, хүүхэд хамгааллын онол, арга зүйн мэдлэг;
- хүний эрх, тогтвортой хөгжлийн боловсрол болон тэгш хамран сургах арга зүйн мэдлэг;
- жендерийн эрх тэгш байдлын ойлголт;
- хүүхдийн сурхай чиглүүлэх, холимог бүлгийн сургалт зохион байгуулах арга зүйн мэдлэг;
- боловсрол, хүүхдийн эрх, хамгааллын хууль тогтоомжийн мэдлэг, ойлголт;
- дотуур байрны орчинд мөрдөх стандарт, шаардлагын талаарх мэдлэг.

### 2.1.2. Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах чадвар:

Хүүхдийн хөгжлийг дэмжих:

- хүүхдийн нас, хөгжлийн онцлог, ялгаатай байдлаас хамааруулан тэдний нийтлэг болон онцлог хэрэгцээг тодорхойлох;
- хүүхдийг аливаа үйл ажиллагаанд тэгш хамруулах, хүүхэд бүрд тэгш боломж олгох, шаардлагатай дэмжлэгийг тухайн нөхцөлд үзүүлэх;
- хүүхдийн хэрэгцээнд үндэслэн тэдний хөгжлийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах, ахиц, үр дүнг үнэлэх, эргэцүүлэл хийх, дүгнэх, тайлагнах;

- хүүхэд хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгах (гэрийн даалгавар хийх), сурх арга барилд хамтдаа суралцах орчин, нөхцөл бүрдүүлэх, зохион байгуулалтаар хангах.

**Хүүхдэд зэрэг зан үйл төлөвшүүлэх:**

- хүүхэд хүмүүжүүлэх арга барилтай байх;
- хүүхдийн давуу тал, сонирхол, хэрэгцээ, гэрийн орчин, хэл, соёлын ялгаатай байдал, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
- хүүхэдтэй эелдэг, алагчлалгүй харилцах;
- үл ойлголцол, маргаан, зөрчилдөөнийг эв зүйгээр, хамтын оролцоотой шийдвэрлэх.

**Хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ:**

- хүүхэд бүрийг тандан судлах, эрсдэлт нөхцөлийг үнэлэх ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулж, хүүхэд хамгааллын хариу арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх;
- хүүхдийн эрх, хамгааллын талаар хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон дотуур байрны бусад ажилтанд зөвлөгөө, мэдээлэл өгөх, хамтран ажиллах;
- хүүхдийн хувийн болон эмзэг мэдээлэл, хувийн орон зайг хамгаалах;
- хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, зан байдлын өөрчлөлтийг таних, шаардлагатай зөвлөгөө өгөх, дэмжин туслах;
- хүүхдийн эрхийн зөрчил гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч, шалтгааныг арилгах арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх.

**Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах:**

- дотуур байрны орчинд хүүхэд дасан зохицох, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болоход дэмжлэг үзүүлэх;
- дотуур байрны орчинд аливаа болзошгүй эрсдэл байгаа эсэхийг хүүхдийн оролцоотой илрүүлэх, хариу арга хэмжээ авах, шийдвэрлүүлэх;
- осол, гэмтэл, гамшиг, гэмт хэрэг, зөрчил, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, халдварт өвчин зэрэг болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар хүүхдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, зааварчилгаа өгөх;
- эрүүл мэнд болон хоол, шим тэжээл, амьдрах ухаанд суралцах, аюулгүй байдлаа хангах чиглэлээр хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх;

**Бусад:**

- менежмент (төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ)-ийн болон манлайлах, хамтран ажиллах, аливаа асуудалд хүлээцтэй хандах, хариу үйлдлээ хянах, хариуцлага хүлээх;
- өөрийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, хөгжүүлэх;
- мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдлийн хувилбар боловсруулах, аливаа асуудлыг амаар, бичгээр илэрхийлэх;
- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх;
- мэдээлэл харилцааны технологи ашиглах.

**Гурав. Дотуур байрны багшийн ажил үүрэг**

3.1.Дотуур байрны багш нь дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах, хамгаалах, сурч боловсрох, хөгжих, төлөвшихэд дэмжлэг үзүүлэх, дотуур байрны өдөр тутмын үйл ажиллагааг

зохицуулах, хүүхдэд тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Энэ шаардлагын 3.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:

3.2.1.дотуур байранд хүүхэд аюулгүй, ая тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.2. хүүхдийн хүсэл сонирхол, хэрэгцээнд суурилан хөгжлийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх, хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгахад чиглэсэн олон талт үйл ажиллагаа (дугуйлан секц, бүлэг, клуб зэрэг хөгжлийг дэмжих үйлчилгээ)-г хичээлийн бус цагаар зохион байгуулах, зөвлөн туслах;

3.2.3.хүүхдэд эерэг зан үйл төлөвшүүлэх, өөрийн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;

3.2.4.хүүхдийг болзошгүй эрсдэл, гэмт хэрэг, зөрчил, дарамт, үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэлд өртөх болон бусад эрсдэлт нөхцөлөөс сэргийлэх, хамгаалах, шаардлагатай дэмжлэг, тусlamж үзүүлэх, холбогдох талуудад мэдэгдэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран хүүхэд хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах;

3.2.5.хүүхдийн нас, хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээ, эрсдэлт нөхцөлийг таних, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, ажил, мэргэжлээ сонгох, аюулгүй амьдрах ухаанд сурх, сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэнд, шим тэжээл, бэлгийн боловсрол зэрэг чиглэлээр заавар, зөвлөгөө өгөх мэргэжлийн үйлчилгээг анги удирдсан багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хоол зүйч, эмч болон холбогдох албан тушаалтантай хамтран тодорхой давтамжтай зохион байгуулах;

3.2.6.дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн оролцооны байгууллагыг холбогдох албан тушаалтантай хамтран чиглүүлэх, дэмжлэг туслах;

3.2.7.дотуур байрны орчин, аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хүртээмжид хүүхдийн оролцоотой үнэлгээ хийх, шаардлагатай хариу арга хэмжээ авах саналыг холбогдох албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлэх;

3.2.8.хуульд заасан бусад.